



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/256

Булган сум

**Уулзвар бүсийн математикийн
олимпиад зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Математикийн багш Д.Сүрэнбатын нэрэмжит уулзвар бүсийн математикийн олимпиадыг зохион байгуулахад хөрөнгө, санхүүжилтийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010365